



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/61

Бэрх хот

**Хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Төсвийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, "Хүүхэд хамгааллын тухай" хуулийн 14 дугаар зүйлийн 14.3 дах заалтыг тус тус үндэслэн үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотын Хүүхэд хамгааллын хамтарсан багийн 2025 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд эрсдэлээс урьдчилан сэргийлж нохойтой айл өрхүүдэд цацруулагчтай хаягжуулалт хийх зардалд 1.035.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 1.035.000 (Нэг сая гучин таван мянган) төгрөгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хууль, дүрэм журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232501061